



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 4/73

Булган сум

Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинхан
их сургуульд суралцаж байгаа оюутны
сургалтын төлбөрт хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, Дээд боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, 24 дүгээр зүйлийн 24.2.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай" IV/25 дугаар тогтоол, 2024 оны IV хуралдааны "Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай" IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Шинхан их сургуультай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд орон нутгийн тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан суралцаж байгаа Пүрэвжаргал овогтой Эмүүжингийн бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлбөрийг олгосугай.

2.Сургалтын төлбөрт шаардагдах 5,194,000 (таван сая нэг зуун ерэн дөрвөн мянга) төгрөгийг 2025 оны хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

